

Нийслэлийн архивын газар



ХҮНС ХАНГАМЖ ТӨВ
ОНӨААТТУГ

Хөмрөг №
Данс №
ХН№

Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
аудитын дүгнэлт

Эхэлсэн: 2018.03.15
Дууссан: 2018.03.15
Хуудасны тоо: 26
Хадгалах хугацааны
жагсаалтын зүйлийн дугаар: ҮЖ-42
Хадгалах хугацаа: Байнга



ХҮНС ХАНГАМЖ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРОЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018.03.15 № 792
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс хангамж ОНӨААТҮГ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

**“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2017
ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн
“Ихмонгол хөлөг Аудит” ХХК
Утас: 70001778

Web: www.imkaudit.mn

С.Тунгалаг
Захирал
Утас: 99061771
e-mail: tungalag.s@imkaudit.mn

Д.Пүрэвжаргал
Аудитор

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

2018 оны 3 дугаар сарын 15

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-тай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 33-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс “Смарт” програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгууллагын захирлын 2013 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар батлагдсан “дотоод хяналт шалгалтын журам”-ыг мөрдөж байна.

Тус байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвээр байна.

Байгууллагын орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдтой 2017 оны 4 сарын 05-ны өдөр байгуулсан 08/2017 тоот гэрээний 1 хавсралтаар Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод 4,240,383.0 мянган төгрөгийн нийт орлого, 4,211,822.29 мянган төгрөгийн зардал, 25,650.64 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 2,850.07 мянган төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 4,641,351.1 мянган төгрөгийн борлуулалтын, 189.4 мянган төгрөгийн хүүгийн, 2,185.7 мянган төгрөгийн тендерийн бичиг баримтын нийт 4,643,726.2 мянган төгрөгийн орлоготой, 4,235,884.0 мянган төгрөгийн борлуулалтын өртөгтэй, 320,621.7 мянган төгрөгийн ерөнхий удирдлагын, 7,657.4 мянган төгрөгийн бусад, нийт 4,564,163.1 мянган төгрөгийн зардалтай, 8,503.5 мянган төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр тооцож, 71,059.5 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны жилийн санхүүгийн тайланд НТАГ-2018/23/СТА-ОНӨААН баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд АОУС-ын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн аж ахуйн нэгж байгууллагын НБББББ-ын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 09-ны хооронд хийхээр төлөвлөн Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн аудитын аудитор Д.Буянравжих, аудиторын туслах Б.Эрдэнэ, М.Батжаргал нар 2018 оны 03 дугаар сарын 09-нд гүйцэтгэв.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлага 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 89 дугаар албан бичгээр, НББ-ийн журнал, анхан шатны баримтуудыг 2018 оны 2 дугаар сарын 3-ны өдөр “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлагад хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлага нь Хөдөлмөрийн, Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, Шилэн дансны, Нийгмийн даатгалын, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Тус газрын дүрмийн 4.1-д “Нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаатай, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана.” гэж заасны дагуу “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирал Б.Ичинхорол нь төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус байгууллага нь Нийслэлийн Засаг даргын баталсан зорилтот түвшинд заасан үйл ажиллагааг явуулан өөрийн орлогоор үйл ажиллагаагаа санхүүжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 15 мэдээллийг байршуулахаас 1 шийдвэрийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 33 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлэн бүртгээгүй, хөрөнгийн дутагдлыг холбогдох эзэн холбогдогчоор төлүүлээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Энэ нь холбогдох хууль, журам, заавар зөрчигдөх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бараа материал, цалин хөлс, үндсэн хөрөнгө, эзэмшигчдийн өмч дансдын ажил гүйлгээг 100 хувь анхан шатны баримттай тулган шалгаж, давтан тооцооллуудыг гүйцэтгэв. Сургалтын, түрээсийн болон бусад зардал дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан горим, сорил нь тус байгууллагын нийт орлогын 98.3 хувь, нийт зардлын 98.6 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитаар Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн 279,672.2 мянган төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

1. Залруулсан алдааны талаар:

- 1.1. Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгад эргэлтийн хөрөнгөөс шилжүүлэн бүртгэсэн 2,664.0 мянган төгрөгийг худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулсан.

- 1.2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23 нэр төрлийн 17,862.4 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглаж байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулсан.

- 1.3. Барилгын зураг төсвийн үнэ 8,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөөр, 36,600.0 мянган төгрөгийн барилгын зураг төсвийн үнийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж, 14,663.0 мянган төгрөгийн элэгдлийг байгуулаагүй байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын эргэлтийн бус хөрөнгө 2-т "Биет бус хөрөнгийг дараахь байдлаар ангилна. Үүнд: 7.Бусад биет бус хөрөнгө: Барилгын

зураг, төсвийн ажил, тенхик эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал” гэж заасныг, НББОУС-38-д” Биет бус хөрөнгө гэж биет чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус хөрөнгө” гэж засан санхүүгийн тайлаганалын толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулсан.

2. Зөвлөмжийн талаар:

- 2.1. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2013 онд боловсруулсан НБББББ-ийг мөрдөж байна. Энэхүү баримт бичигт шинэчлэн баталсан хууль, тушаал, заавар, стандартуудын дагуу өөрчлөлт оруулахгүйгээр мөрдөж ирсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

- 2.2. Бараа материалын үлдэгдлийг няравын агуулахын бүртгэлийн үлдэгдэлтэй тулгахад 292.8 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь харилцагч байгууллагуудад олгоогүй, түгээгч няравуудад үлдэгдэлтэй байгаа бараа материалыг орлогод аваагүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

- 2.3. Харилцагч байгууллагуудаас бараа материал хүлээн авсан орлогын баримтыг авч тооцоог тулгадаггүй, зөвхөн өөрийн байгууллагын зарлагын баримтыг үндэслэн бүртгэлийг хөтөлж байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д “Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан, хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

- 2.4. Нийт 5 байгууллагын 31,676.5 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасныг, санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

- 2.5. Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлээгүй, эх үүсвэрийн дүнгээр эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд 166,629.7 мянган төгрөгийг бүртгэж ирсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 17-д "Эздийн өмчийн бусад хэсэг"-ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаур олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэхь хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

3. Албан шаардлагын талаар:

- 3.1. 2016 оны 12 сарын 31-нээр жолооч П. Ганболд нь 3.6 тн махны үнэ 15,828.2 мянган төгрөгийг дутагдуулсныг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байсан байна. Үүнийг нягтлан бодогч Н.Цэрэнбанзад нягтлан бүртгэлд авлагаар бүртгэсэн боловч барагдуулаагүй байна.

Энэхүү дутагдлыг хөрөнгөөр хаахаар Нийслэлийн өмчийн харицлааны газарт 2017 оны 05 дугаар сарын 31-ий өдрийн 105 тоотой хүсэлт тавьсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Журам, заавар мөрдөөгүйгээс гарсан 232,289.7 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

2017 оны аудитаар илэрсэн зөрчлүүдийг шалгаж орон нутгийн өмчийн талаар эрх бүхий дээд байгууллагуудын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 294,216.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба 61,927.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг залруулж, 216,461.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч, 15,828.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС,СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.


Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 5 хуудас, хавсралтууд 10 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хоёр дахь шатанд хянасан:
Ихөмөнгөл хөлөг Аудит ХХК-ийн
Захирал

Хоёр дахь шатанд хянасан:
Чанарын хяналтын мэргэжилтэн

Гүйцэтгэсэн:
Аудитор



С.Тунгалаг

С.Сожидмаа

Д.Пүрэвжаргал

**“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичгийн талаар12

Асуудал 2

Бараа материалын талаар..... 13

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн талаар.....14

Асуудал 4

Өр төлбөрийн талаар.....15

Асуудал 5

Эзэмшигчийн өмчийн талаар.....16

2018 оны 3 дугаар сарын 13

Менежментийн захидал

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн
бодлогын баримт бичгийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ажиглалт

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2013 онд боловсруулсан НБББББ-ийг мөрдөж байна. Энэхүү баримт бичигт шинэчлэн баталсан хууль, тушаал, заавар, стандартуудын дагуу өөрчлөлт оруулахгүйгээр мөрдөж ирсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн зөвлөмж

Шинэчлэгдэн батлагдсан нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 77, 249, 297 дугаар тушаалууд болон холбогдох стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулж мөрдөх, үндэсний стандартын дагуу НБББББ-ийг дахин боловсруулж, батлуулж мөрдөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Асуудал 2: Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

**Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн
ажиглалт**

Бараа материалын үлдэгдлийг няравын агуулахын бүртгэлийн үлдэгдэлтэй тулгахад 292,845.00 төгрөгөөр илүү байна. Энэ нь харилцагч байгууллагуудад олгоогүй, түгээч няравуудад үлдэгдэлтэй байгаа бараа материалыг орлогод аваагүйгээс шалтгаалсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д" хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг мөрдөөгүй байна.

Харилцагч байгууллагуудаас бараа материал хүлээн авсан орлогын баримтыг авч тооцоог тулгадаггүй, зөвхөн өөрийн байгууллагын зарлагын баримтыг үндэслэн бүртгэлийг хөтөлж байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д" Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан, хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн зөвлөмж

1. Түгээч няравуудын тараагдаагүй үлдэгдлийг тухай бүрд орлогод авч байх.
2. Түгээч няравуудад үлдэгдэл гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх.
3. Ажил гүйлгээ бүрийг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаж байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

**Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн
ажиглалт**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23 нэр төрлийн 17,862,400.00 төгрөгийн хөрөнгийг ашиглаж байна.

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн зөвлөмж

2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 193 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-1/3549 дугаар албан бичгүүдийн дагуу газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын бэлтгэлийг хангаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн дахин үнэлгээнд бүрэн хамруулах зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар ирүүлэх.

Эрсдэлүүд

Хөрөнгийг ашиглах, шамшигдуулах эрсдэл үүсэх

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Асуудал 4: Өр төлбөрийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №4

**Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн
ажиглалт**

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн зөвлөмж

Нийт 5 байгууллагын 31,676.5 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч, үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар ирүүлэх.

Эрсдэлүүд

Үйлчлүүлэгчийн хариу

Найдваргүй өр авлага үүсэх.

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Асуудал 5: Эзэмшигчийн өмчийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

**Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн
ажиглалт**

Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлээгүй, эх үүсвэрийн дүнгээр эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд 166,629.7 мянган төгрөгийг бүртгэж ирсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 17-д "Эздийн өмчийн бусад хэсэг"-ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаур олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэхь хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна

Эрсдэлүүд

Хууль тогтоомжийг мөрдөхгүй байх, орон нутгийн өмчийг ашиглах, шамшигдуулах

Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн зөвлөмж

Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэгдсэн 166,269,728.30 төгрөгийн дүнгээр нийслэлийн өмчийн харилцааны газарт уламжлан холбогдох шийдвэрийг гаргуулан эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

Хоёр дахь шатанд хянасан:
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Ихмонгол хөлөг Аудит ХХК

Захирал

Анхан шатанд хянасан:

Чанарын хяналтын мэргэжилтэн

Гүйцэтгэсэн:
Аудитор



С.Тунгалаг

С.Сожидмаа

Д.Пүрэвжаргал

2018 оны 3 дугаар сарын 13

**“ХҮНС ХАНГАМЖ” ОНӨААТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,6046,730.07	22,178,517.46
Дансны авлага	5,023,800.00	5,010,958.00
Татвар, НДШ-ийн авлага	35,000.00	26,426.74
Бусад авлага	4,666,890.00	20,614,776.01
Бараа материал	59,809,802.51	111,262,338.25
Урьдчилж төлсөн зардал /Тооцоо/	37,475,000.00	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	123,057,222.58	159,093,016.46
Үндсэн хөрөнгө	183,410,871.57	170,490,493.62
Биет бус хөрөнгө	270,000.00	34,091,931.64
Бусад эргэлтийн бус хөрөнгө	8,000,000.00	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	191,680,871.57	204,582,425.26
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	314,738,094.15	363,675,441.72
Дансны өглөг	41,348,549.00	31,676,530.00
Татварын өглөг	144,571.58	4,798,860.10
Богино хугацаат өр төлбөрийн дүн	41,493,120.58	36,475,390.10
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	41,493,120.58	36,475,390.10
Өмч Төрийн	1,000,000.00	1,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг	166,629,728.30	166,629,728.30
Хуримтлагдсан ашиг	105,615,245.27	159,570,323.32
Эздийн өмчийн дүн	273,244,973.57	327,200,051.62
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	314,738,094.15	363,675,441.72

**“ХҮНС ХАНГАМЖ” ОНӨААТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	4,098,070,836.03	4,641,351,167.00
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,792,389,815.52	4,235,884,028.18
Нийт ашиг/алдагдал	305,681,020.51	405,467,138.82
Хүүгийн орлого	56,732.10	189,419.29
Бусад орлого	3,992,929.00	2,185,608.60
Борлуулалт маркетингийн зардал	223,798,339.96	-
Ерөнхий ба удирдлагын зардал	73,969,154.37	335,284,693.32
Бусад зардал	6,498,292.00	7,657,448.00
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	5,464,895.28	64,900,025.39
Орлогын албан татвар	1,636,818.73	7,255,747.34
Татварын дараах ашиг/алдагдал	3,828,076.55	57,644,278.05

“ХҮНС ХАНГАМЖ” ОНӨААТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	166,629,728.30	105,615,245.27	273,244,973.57
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	166,629,728.30	105,615,245.27	273,244,973.57
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	57,644,278.05	57,644,278.1
Зарласан ногдол ашиг	-	-	(3,689,200.00)	(3,689,200.0)
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.00	166,629,728.30	159,570,323.32	327,200,051.62

“ХҮНС ХАНГАМЖ” ОНӨААТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгөн орлогын дүн	4,112,333,274.03	4,656,718,361.29
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,108,767,016.03	4,648,309,505.00
Бусад мөнгөн орлого	3,566,258.00	8,408,856.29
Мөнгөн зарлагын дүн	4,135,683,740.61	4,639,077,373.90
Ажиллагчдад төлсөн	130,778,930.51	148,859,783.63
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,187,578.73	36,976,616.17
Бараа материал авахад төлсөн	3,848,454,834.00	4,334,551,284.00
Ашиглалтын зардалд төлсөн	2,006,611.32	53,874,060.72
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,866,200.00	20,646,761.00
Татварын байгууллагад төлсөн	19,233,606.65	18,192,977.04
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		506,790.00
Бусад мөнгөн зарлага	96,155,979.40	25,469,101.34
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,350,466.58)	17,640,987.39
Мөнгөн орлогын дүн	8,343,769.10	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	8,287,037.00	-
Хүлээн авсан хүүний орлого	56,732.10	-
Мөнгөн зарлагын дүн	(9,210,600.00)	(7,370,000.00)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	120,000.00	2,970,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		4,400,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	9,090,600.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(866,830.90)	(7,370,000.00)
Мөнгөн орлогын дүн	18,611,684.52	-
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	18,611,684.52	-
Мөнгөн зарлагын дүн	4,787,900.00	4,139,200.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,600,000.00	-
Төлсөн ногдол ашиг	2,187,900.00	3,689,200.00
Бусад	-	450,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,555,869.10	(4,139,200.00)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,823,784.52	(4,139,200.00)
Валютын ханшны зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(10,393,512.96)	6,131,787.39
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,440,243.03	16,046,730.07
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,046,730.07	22,178,517.46

**“ХҮНС ХАНГАМЖ” ОНӨААТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт		2016 он	2017 он		Төлөвлөгөөнөөс	
			Зорилт	Биелэлт	зөрүү	хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр	Хэрэглэгч байгууллага	41	43	45	(2)	105%
	Хүүхдийн тоо	12,000	12,800	12,800	-	100%
	Гэрээт аж ахуй нэгж байгууллага	31	31	31	-	100%
	Нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	168	171	178	(7)	104%
Нийт орлого		4,102,120.4	4,240,383.0	4,643,726.2	403,153.8	110%
Үүнээс	Борлуулалтын орлого	4,098,070.8	4,238,883.0	4,641,351.2	402,468.2	109%
	Үндсэн бус бусад орлого	3,992.9	1,500.0	2,185.6	685.6	146%
	Хүүгийн орлого	56.7		189.4	189.4	
	Авто зогсоол				-	
	Ногоо				-	
	Засвар				-	
	бусад				-	
Нийт зардлын дүн		4,096,655.6	4,211,882.3	4,564,163.2	352,280.9	108%
Үүнээс	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,792,389.8	3,899,772.4	4,235,884.0	336,111.6	109%
	Аж ахуйн үйл ажиллагааны зардал	297,767.5	306,109.9	320,621.7	14,511.8	105%
	Үйл ажиллагааны зардал	6,498.3	6,000.0	7,657.5	1,657.5	128%
Татвар төлөхийн өмнөх ашиг		5,464.8	28,500.7	79,563.0	50,872.9	279%
Орлогын албан татвар		1,636.8	3,450.1	8,503.5	5,053.4	246%
Цэвэр ашиг		3,828.0	25,050.6	71,059.5	46,008.9	284%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал		1.0	0.99	0.98	(0.01)	99%



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/70

Улаанбаатар хот

НТАГ - 2018/23/СТА-ОНӨ ААН

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2016 оны 12 сарын 31-нээр жолооч П.Ганболдын дутагдуулсан 3.6 тн махны үнэ 15 828194.00 /Арван таван сая найман зуун хорин найман мянга нэг зуун ерин дөрөв/ төгрөгийг төлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8- д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны а/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.7 "Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

- Өр төлбөрийн үлдэгдэл тооцоог 2018 оны 5 дугаар сарын 25-ны дотор барагдуулах.

Албан шаардлагын биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын захирал Б.Ичинхорол, Нягтлан бодогч Н.Цэрэнбанзад нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ


ӨГСӨН¹:

ЗӨВШӨӨРСӨН:

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

 /Д.ПҮРЭВЖАРГАЛ/

ХҮНС ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ

 /Б.ИЧИНХОРОЛ/
НЯГТЛАН БОДОГЧ

 /Н.ЦЭРЭНБАНЗАД/

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

САНХҮҮГИЙН АУДИТЫН II ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

 Д.ЭНХДАЛАЙ
 Т.БАТ-ӨЛЗИЙ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу-1, Хөвсгөл лэйк сити төвөр-8/1, 3-р давхар
Утас/Факс: (976-11) 32-02-48
<http://www.umch.ub.gov.mn>

2018.03.14 № 2/381


танай _____-ны № _____-т

"ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ" ХХК-Д

Танай байгууллагын санхүүгийн аудит хийж байгаа "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ийн балансд авлагаар бүртгэлтэй 15,8 сая төгрөг нь 2016 онд ажиллаж байсан жолооч П.Ганболдын буруутай үйлдлийн улмаас мах муутгаснаас үүссэн болно. Тус махны өр төлбөрт жолооч П.Ганболд өөрийн эзэмшлийн Nissan sagavan маркийн авто машиныг шилжүүлэн өгөхөөр тохиролцсон байна.

Иймд манай байгууллага тус автомашины зах зээлийн үнэлгээг үнэлгээний байгууллагаар хийлгэн өр төлбөрийг барагдуулах талаар холбогдох хүмүүст шаардлага тавин ажиллаж байгаа болно.

ОРЛОГЧ ДАРГА *[Signature]* Д.МӨНХСАЙХАН



Doc A5

115050000482